

ДОРНОД МОНГОЛЫН ЭРТ ДУНДАД ҮЕИЙН НҮҮДЭЛЧИД

3.БАТСАЙХАН

МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим
batsaikhan@num.edu.mn

Түлхүүр үс: Хүннү булш, монгол булш, шагай чөмөг

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ. 2003 оны хээрийн хайгуул судалгаагаар Өгөөмөрийн Цувераа ууланд орших археологийн дурсгалуудыг малтан судлах ажлыг эхэллээ. Цувераа уулын баруун талын залгаа толгой Тахилгат овоо, зүүн урд талд нь орших Баян уул, Баян уулын зүүн суга зэрэг 3-4 км газарт хүрлээс эхлээд XIY зуун хүртэлх үеийн янз бүрийн хэв шинжийн 300 гаруй булшийг илрүүлэн ихэнх булшуудын солбицлыг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ удаагийн экспедиц Тахилгат уул, Цувераа уулын ард орших том дөрвөлжин байгууламж, Баян уулын зүүн суга зэрэг газарт шинэ малталь судалгаа зохион явуулснаас гадна зарим газарт хайгуул судалгаа хийллээ.

Хэнтий, Дорнод аймгуудад зохион явуулж байсан археологийн судалгааны явцад түүхэн үе бүрийн олон хэв шинжийн археологийн дурсгалуудыг илрүүлэн олжээ. Ялангуяа, наяд оны эцсээр эхэлсэн Чингис хааны онгоныг эрж хайх Монгол, Японы хамтарсан “Гурван гол” төслийн хүрээнд Төв ба Хэнтий аймгийн хойд талын сумдын нутагт өргөн хүрээтэй хайгуул судалгаа хийгдсэн (Gurvan Gol, 1991-1993).

Судалгааны үр дүнгээс үзэхэд хангайн нэг сумын нутагт ойролцоогоор 300-500 орчим янз бүрийн хэв шинжийн археологийн дурсгал байдаг ажээ. Түүнчлэн, 1960-аад оны үед ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргаж байсан “Гурван гол” экспедицийн шугамаар Хэнтий, Дорнод аймгийн нутагт ойролцоогоор 400 орчим дөрвөлжин булшийг малтан судалсны зэрэгцээ олон тооны дурсгалт газрыг шинээр илрүүлэн олсон байна (Наваан, 1975).

1997 оноос эхлэн МУИС-ийн Антропологи-археологийн тэнхмийн хээрийн дадлага-судалгааны экспедиц явуулахдаа Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан ууланд түүхийн олон үеийн дурсгал бүхий газар, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутагт дундад эртний монголчуудын томоохон оршуулгын газар болон 70 гаруй хүннү булштай дурсгалт газрыг Дорнод Монголоос шинээр илрүүлж судлан шинжилж байна.

Гэвч судалсан байдлаас харахад харилцан адилгүй түвшинд судлагдсан бөгөөд гол төлөв он цагийн хамаарлыг тогтоох зорилгоор явуулын аргаар

судалж өргөн хүрээтэй малтарт судалгааны ажил огт хийгээгүй байгаа ба ихэнх материал нь эдүгээ хүртэл судалгааны хүрээнд бүрэн бүтэн ороогүй байна.

2003 онд археологийн хээрийн судалгаа голлон явуулсан газар нь Дорнод аймгийн Хөлөнбуйр сумаас баруун урагш 5 км зйтай оршино. Хойт талаараа Хэрлэн гол урсах бөгөөд голын хөндийн хурдастай залган Дорнод Монголын бэсрэг уулс үргэлжлэх бөгөөд зүүн болон урд талаараа дорнодын дов толгод тал хээртэй залгадаг ажээ. Тал хээрийн энэхүү онцгой бүсэд археологийн дурсгалууд гол төлөв Хэрлэн голын хөндий сав түүний дагуух уулсын энгэр бэлээр тохиолдоно.

Хөлөнбуйр сумын хүн амын үндсэн хэсэг нь 1945 онд Өвөр Монголын Хөлөнбуйраас нүүдэллэн ирж суурьшсан баргууд бөгөөд эдүгээ хэл аялгын хувьд халхжиж ялгаагүй болсон байна. Баргуудын дотор овог ясаа мэддэг хүмүүс цөөнгүй тохиолдох бөгөөд буриадын зарим овог хүртэл байх ажээ.

2003 оны хээрийн хайгуул судалгаагаар өмнө өгүүлсэн газрыг илрүүлэн олж малтан судлах ажлыг Өгөөмөрийн Цувраа ууланд эхэлсэн юм. Түүнчлэн, Цувраа уулын баруун талын залгаа толгой Тахилгат овоо, зүүн урд талд нь орших Баян уул, Баян уулын зүүн суга зэрэг 3-4 км газарт хүрэлзээс эхлээд XI-XII зуун хүртэлх үеийн янз бүрийн хэв шинжийн 300 гаруй булшийг илрүүлэн ихэнх булшуудын солбилцлыг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ удаагийн экспедиц Тахилгат уул, Цувраа уулын ард орших том дөрвөлжин байгууламж, Баян уулын зүүн суга зэрэг газарт шинэ малтарт судалгаа зохион явуулснаас гадна зарим газарт хайгуул судалгаа хийлээ.

Археологийн хайгуул судалгааг Хөлөнбуйр сумаас зүүн зүг 11 км зйтай газарт орших Өлзийт уулын орчим явууллаа. Өлзийт уул Хэрлэн голын урд 5 км орчим зйтай Чойбалсан хот явдаг замын урд оршино. Нутгийнхны дунд Өлзийт ууланд “Чингисийн морины уяа”, “ор” гэх мэтээр домоглон ярьдаг чулуу байх бөгөөд эртний тахилгатай уул ажээ. Түүнчлэн олон тооны булштай гэдэг.

Өлзийт орчмын уулсаар хайгуул хийж үзэхэд дээрх яриа ор үндэсгүй болох нь тогтоогдсон бөгөөд харин Өлзийт уулын урд бэл хормойд зууван дугуй хэлбэртэй 250-300 см хэмжээтэй 6 булш байлаа. Эндээс зүүн зүгт 3 км зйтай Дорнод явдаг замын хойт талд нэгэн багавтар хүн чулуун хөшөө байх ба Өлзийтийн хүн чулуу гэж нэрлэдэг ажээ. Хөшөөг урагш харуулан зоосон байх бөгөөд 100 см өндөр нүүрний өргөн 30 см, цээжний өргөн 60 см, доод тал уруугаа нарийсч шувтан хэлбэр үүсгэжээ. Нүүрний хэлбэр нь духаараа хавчиг, хацар өргөн, нүд, хөмсөг хамар, ам төдийлөн тод бус боловч харагдахуйц,

сахалгүй боловч түрэгийн хүн чулуудтай нүүрийг дүрсэлсэн байдал ижил төстэй сурлэг. Хоёр гарыг цээжинд зөрүүлэн авсан байх ба баруун гарт хундага мэт зүйлийг өргүүлжээ. Хөшөөнд гэзэг үс, хувцас хунарын аль алийг нь онцлон гаргаагүй ажээ.

Дээрх хөшөөнөөс баруун тийш 3 км өргөн 5 км урт талбайд буюу Хэрлэн гол хүртэлх тэгш талд нарийвчилсан хайгуул хийж үзэхэд ямар нэг дурсгал тохиолдсонгүй.

Хайгуул судалгааны явцад ажиглагдсан нэг зүйл бол тухайн нутагт Хэрлэн голын өмнөд этгээдээр дөрвөлжин булш маш цөөн ганц нэгээр тохиолдох бөгөөд их төлөв 7-8 м том байхаас гадна дөрвөн буланд асар том бахим чулуу босгосон байна. Мөн Монгол орны ихэнх нутагт түгээмэл байх хиргисүүр болон хиргисүүр маягийн дурсгалууд огт байхгүй байгаа нь түүний тархалтын хил хязгаар дуусвар болж байгааг харуулж байгаа бололтой.

Түүнчлэн, Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт төв замын урд Баруун, Зүүн хэрмийн хойд талд 80 см өндөр хүн чулуун хөшөөг шинээр илрүүлэн оллоо. Хүн чулууны нүүрийг тод сайн сийлсэн байх бөгөөд юудэн маягийн малгайтай мөн сахалтай дүрсэлжээ.

Түрүү нүүдэлчдийн дурсгал. Өмнө өгүүлснээр Баян ууланд нийт 70 гаруй булштай хоёр бүлэг хүннү булш байхаас гадна Цувраа уулын ар хормойд 10x10 хэмжээтэй дөрвөлжин байгууламжийг малтан судлахад төвийн дараас чулуун доор орших нүхнээс Хан улсын үеийн хагархай цагаан хүрэл толь олдсон бөгөөд дээрхийн ижил TLV цагаан хүрэл толь хүннү булшнаас олонтаа гардаг эд өлгийн нэг юм. Иймээс дээрх байгууламж нь он цагийн хувьд Хүннүгийн үед холбогдож болох талтай бөгөөд ер нь эдүгээ мэдэгдэж байгаа хүннү язгууртны булшууд нь дөрвөлжин хэлбэртэй байхаас гадна уулын арын энгэр газар оршдогтой адил байна (Батсайхан, 2002). Хүннүгийн археологийн хэрэглэгдэхүүнд дээрхийн ижил байгууламж малтан судалсан тухай мэдээ хараахан гараагүй байгаа боловч хүннү нар тахилга тайлагын үеэр тусгай байгууламж барих ёс заншилтай байсан ажээ. Сурвалжийн мэдээ заалтаас үзвэл хүннү нар газар, тэнгэр болон Модун шаньюйд зориулан тахилга тайлага хийж гүйцэтгэж байсан мэдээ бий (Таскин, 1989). Баян уул болон түүний салбар уулс нь Хэрлэн голоос урд зүгт 4-5 км-т голын дагуу үргэлжилнэ. Баян уулын зүүн суганы эсрэг этгээдэд хэзээ нэгэн цагт устай байсан бололтой Хэрлэнг чиглэсэн хуурай сайр байх бөгөөд эхэнд нь Сантын хэмээх ундарга сайтай нэгэн худаг бий. Баян уулын зүүн суга нь зүүн тийш харсан багавтар ам бөгөөд амны

дунд хотгорт цуварсан тавь гаруй булш орших бөгөөд хэмжээний хувьд бүгд ойролцоо, ялгарахуйц том булш байхгүй байна. Харин амны адагт байх хуучин өвөлжөөний баруун хойно зэрэгцээ, мэдэгдэхүйц гурван хонхор байлаа.

Баян уулын булшуудын гадаад байгууламжийн дараас чулуу цөөн ихэвчлэн зөв бус дугуйвтар хэлбэртэй ажээ. Энд амны эхэнд орших ойролцоо З булшийг малтан судлахад нас барагчийг бэнзэн авсанд тавьж толгойг хойт зугт чиглүүлэн зэр зэвсэг, хутга, жад болон Хан улсын үеийн TLV хэв шинжийн цагаан хүрэл толь зэргийг дагуулан оршуулсан байна. Өвөр Байгал, болон Умард Монголд хүннүгийн дурсгалыг судалсан байдлаас үзвэл их төлөв бага болон өсвөр насны хүүхдийг тусгайлан оршуулдаггүй байсан бол (Төрбат, 2004) Баян уулын 6-р булшинд 10 орчим насны хүүхдийг бэнзэн авсанд тусгайлан оршуулсан байлаа. Түүнчлэн, дээрх гурван булшнаас адуу малын тахилгын яс огт гараагүйгээс гадна 6-р булшнаас гарсан хагархай ваар савыг эс тооцвол шавар сав суулгын зүйл байсангүй. Энэхүү ваарны хагархай хэсгүүдээс үзвэл хэлбэр, хийсэн арга болон найрлагын хувьд хүннү ваартай ижил байлаа.

Хүннү булшинд зүймэл нумын ясан наалт, зэв зэргийг эрэгтэй хүний булшинд ёс мэт дагуулан тавих боловч илд, жад мэт төмөрлөг зэвсгийг төдийлөн түгээмэл тавьдаггүй тал ажиглагддаг. Энэ нь зэвийг бодвол цөөн тоогоор хийдэг түүнчлэн илд, жадыг хийх ажил харьцангуй нарийн түвэгтэйгээс гадна дайн тулааны гол зэвсэг байсантай холбоотой байж болох талтай. Гэвч, сүүлийн жилүүдэд Хэнтий, Сүхбаатар зэрэг аймагт хүннү булш малтах явцад хоёр өөр хэв шинжийн жадны гилбэр олдсон бол Баян уулын 8-р булшнаас цул төмрийг давтаж хийсэн өвөрмөц хэв шинжийн жадны гилбэр гарсан байна. Судалгаанаас үзвэл хүннү цэргийн гол зэвсэг нум сум, илд, жад байжээ. Уг булшинд настайвтар эрэгтэй хүнийг дугуй төмөр товруутай бэнзэн авсанд тавьж таван метрийн гүнд оршуулсан байлаа. Түүнчлэн TLV маягийн цагаан хүрэл толийг хагалан үйсэн уутанд хийж дагуулан тавьсан зэргээс үзвэл амьд ахуйдаа тухайн овог аймгийн дотор ямар нэг тодорхой үүрэгтэй хүн байсан бололтой. Ер нь хүрэл толийг гол төлөв эмэгтэй хүнд дагуулдаг эд өлгө боловч зарим тохиолдолд эрэгтэй хүнд дагуулан тавьсан байх нь ажиглагдана. Гэхдээ эрэгтэй хүнд дагуулан тавьсан тохиолдолд эд өлгийн цогц нь нилээд баялаг байхаас гадна мөн жадны гилбэр дагуулсан байдгийг дурдаж болох юм. Эртний шүтлэг бишрэлийн ойлголт төсөөллөөр амьгүй эд юмст хүртэл сүнс байдаг хэмээн үздэг учир нас барагчийн эд зүйлийг булшинд эвдэж тавих явдал түгээмэл байсан бөгөөд энэ ёс хүрэл толин дээр тодорхой илэрч байдаг.

Булшны гадаад дотоод зохион байгуулалт, эд өлөг болон оршуулгын зан үйлийн бүхий л элементээрээ Баян уулын булшууд нь Монгол болон хөрш зэргэлдээ газар нутагт малтан судалсан хүннү булшуудтай ижил байгаа бөгөөд монголын хамгийн зүүн зах хязгаарт оршиж буй хүннүгийн дурсгал болно. Энэ талаас нь авч үзвэл хүннүгийн археологийн дурсгалын тархалтын хүрээ болон Хүннү улсын газар нутаг, хил хязгаарын асуудлыг судлах шинэ хэрэглэгдэхүүн болж байгаа юм.

Дундад эртний үеийн дурсгалууд. Өмнө өгүүлсэн Цувраа болон Тахилгат ууланд тус тус 80 гаруй хоёр бүлэг булш байсан ба өнгөрсөн жил зөвхөн Цувраа ууланд малтالت зохион явуулсан бол энэ жил Тахилгат уулын булшуудын солбилцлыг дахин тодорхойлж 12 булшийг малтан судаллаа. Чингэхдээ уг оршуулгын газрын дотоод байр зүйд ямар нэг ялгаа буй эсэхийг тогтоохын тулд уулын хормой, энгэр болон оройн хэсэгт сонгосон булшуудыг малтан судлах арга зүйг хэрэглэв. Уг арга зүйгээр малтالت судалгааг зохион явуулахад уулын оройд ойр орших зэрэгцээ хоёр булшнаас сумтай үйсэн саадаг, хоёр дахь булшнаас багтого малгай зэрэг эд өлгийн зүйлс олдсон байна. Дээрхийн ижил үйсэн саадаг Чойбалсан хотоос зүүн тийш 40 км-т Хэрлэн голын баруун эрэгт малтан судалсан 3-р булш, мөн Хоолтын голын 2-р булшнаас гарсан байна (Асеев, 1975:181,183).

Богтого малгайн тухай хамгийн анхны бүрэн тэмдэглэлийг 1220-1221 онд Монголд ирсэн Өмнөд Сүн улсын элчин Чжао Хун хийжээ. Үүнд: "Ахлагч нарын бүх эхнэрүүд гу-гу малгай өмсөнө. Энэ малгайг утсаар (юн те сы це-мен үсэгчилбэл "төмөр утсаар сүлжих") сүлжиж хийнэ. Хэлбэрийн хувьд (нанхиадын) хулсан эхнэртэй ижил агаад гурван чи (1 чи 0.32 см) гаруй өндөр ажээ. Түүнийг хатгамал угалз бүхий хар хүрэн өнгийн бөсөөр бүрж алт, сувдаар чимэглэмүй. Орой дээр нь (ёрдойсон) саваа байна. Үүнийг хар хүрэн өнгийн бөсөөр чимэглэнэ" гэжээ (Мэн-Да Бэй-лу, 1975). П.Карпини, В.Рубрук нар модны хальс (үйс-3.Б) мөчир, ер нь аль олдохуйц эдээр хийж (Н.П.Шастина, 1975) гол төлөв бараан өнгийн цэмбэ, чинээлэг эхнэрүүд улаан өнгийн бөсөөр (Пэн да-я и Сюйтина, 1960), бухар даавуу, эсвэл ал улаан бөс, багдад торго, хоргойгоор (Н.П.Шастина, 1975) бүрдэг тухай дурдсан байна. Хэмжээ болон хэлбэрийн талаар нэг тохой өндөр, доороос дээшлэх тутам өргөсөх ба орой нь дөрвөлжин (Н.П.Шастина, 1975) хоёр чи орчим өндөр, дээд талын хэсэг нь галуу, нугастай адил (Си Ю Цзи, 1866), нэг тохой өндөр, орой нь баганы капитель шиг дөрвөлжин, дотроо хөндий бөгөөд мөрөө хүрсэн шилэвчтэй малгай дээр уг

заслыг оёж тогтооно (Н.П.Шастина, 1975) гэж тодорхойлсон байхад Юн-лэ да дань хэмээх их нэвтэрхий толь бичигт хэмжээний хувьд том, дунд, жижиг гэсэн гурван зэрэг багтого буйг заажээ (Мэн-Да-Бэй-лу, 1975).

Монгол оронд сүүлийн үед Хэнтий, Сүхбаатар, Төв, Сэлэнгэ, Булган, Дундговь, Дорнговь, Өвөрхангай аймгуудад явуулсан хээрийн судалгаагаар нэлээд хэдэн багтого малгай олдсоноос гадна Байгаль орчмын нутаг (Волков, 1963; Хамзкина, 1969; Асеев, 1980; Ковычев, 1981; Наваан, 1983; Асеев, Кириллов, Ковычев, 1984; Мэнэс, 1988; Батсайхан, 1990), Ижил мөрний сав нутаг буюу Монголын Алтан ордны улс тогтнож байсан нутаг (Федоров-Давыдов, 1966), Ирчис мөрний сав газар (Арсланова, 1963) зэрэг монгол угсаатан идээшин сууж байсан газруудаас олдож байгааг дурдах хэрэгтэй.

Багтогыг булшинд тавихдаа толгойд углах оройн хэсгийг нь салган тавих бөгөөд судрын чуулганд өгүүлснээр Тулуйг нас барагад Гүюгийн хатан гашуудлаа илэрхийлж өөрийн багтаг малгайн оройг Тулуйн хатанд илгээсэн байдаг (Рашид Ад дин, 2002).

Ийнхүү уулын оройн хэсэгт булшнаас чанарын хувьд энгэр бэлээр байх булшуудаас илүү эд өлөг гарсан боловч шууд дүгнэлт хийхэд хангалтгүй харьцангуй цөөн тооны булшийг малтан судалсныг тэмдэглэх хэрэгтэй.

Тахилгат уулын булшууд нь 250-400 см дугуйттар ба зууван дугуй хэлбэртэй, 2-3 давхар чулуун дараастай, ойролцоогоор 100 см орчим гүн байх бөгөөд ихэвчлэн ямар нэг нэмэлт байгууламжгүй нүхэнд умраас зүүн зүгийн хооронд толгойг нь чиглүүлэн эмэгтэй хүнд сувс, ээмэг, хүрэл толь, эрэгтэй хүнд зэв, хоромсог, хутга зэргийг дагуулан оршуулсан байна.

Тахилгат уулын булшуудаас хавтгай зэв зэрэг зэвсгийн зүйлс цөөнгүй олдсон бөгөөд ийм хэв шинжийн зэв МЭ I мянган жилийн эхнээс эхлэн өргөн дэлгэрсэн бөгөөд нүүдэлчдийн дурсгалаас гардаг гол эд өлгийн нэг болдог. Түүнчлэн 6-р булшнаас гарсан сүүжин ээмэг Евразийн тал нутгийн монгол түрэг нүүдэлчдийн дурсгалд цөөнгүй тохиолдох бөгөөд гол төлөв өрөөсөн байгаагаас үзвэл аль нэг чихэндээ (магадгүй баруун) зүүх заншилтай байсан бололтой ба энэ нь маш эртний уламжлалтай байж болох талтай. Хүннү булшуудаас дээрхийн ижил өрөөсөн сүүжин ээмэг гарах бөгөөд өрөөсөн ээмэг зүүх ёс тухайн ард түмний шүтлэг бишрэл түүнчлэн элдэв билэгдэлтэй холбоотой бололтой.

Судалгааны хэрэглэгдэхүүнээс үзвэл YII зууны үеэс эхлэн булшинд шагай чөмөг дагуулах ёс үзэгдэж эхэлсэн бөгөөд ийм булшуудыг эртний монголчуудын дурсгал гэж үздэг бөгөөд XII-XIV зуунд улам дэлгэрч оршуулгын зан үйлийн нэг

гол тодорхойлогч элемент болсон байна (Именохоев, 1989). Тахилгат уулын булшууд нь оршуулгын зан үйлийн хувьд дундад эртний монголчуудын дурсгалтай бүх талаараа ижил төстэй байгаа боловч шагай чөмөгтэй булш цөөн байна. Чухам энэ шинжээр нь авч үзвэл Монгол овог аймгуудын дотор харь гаралтай угсаатны бүлгүүд цөөнгүй оролцсоныг харуулах нэгэн шинж тэмдэг байж болох юм.

Хэрэглэгдэхүүнээс үзвэл монголчуудын оршуулгын зан үйлийн нийтлэг шинж төрх хэлбэршин тогтох үйл явц VII зууны үед Өвөр Байгальд тавигдаж XIII-XIV зуунд Монголоос Алтан ордны улс хүртэлх өргөн уудам газар нутагт нэгэн нэгдмэл болсон байна. Монголчуудын оршуулгын зан үйл хэлбэршин тогтох үйл явц ийнхүү урт удаан хугацаанд үргэлжилсэн нь тухайн үед тогтсон эзэмшил газаргүй угсаа гарвалын хувьд алаг эрээн олон биеэ даасан байдалтай овог аймгууд зэрэгцэн оршиж байсантай холбоотой байж болох талтай.

Сурвалжийн мэдээгээр 618-620 оны хооронд Теле аймгуудад Сиеяньто, Киби, Хуйхэ, Дубо, Гулигань, Доланьгэ, Пугу, Байегу, Тунло, Хунь, Сыцэйе, Хусие, Си, Адье, Байси зэрэг аймгууд орж байсан бол 647 онд Кидан нэмэгдсэн байжээ (Кюнер, 1961:36, 37). Дурдсан овог аймгуудын зарим нь монгол болон хөрш зэргэлдээх газар нутагт түрэгийн хараат байдалтай оршин сууж байгаад Илан хааны үед Токоз-Огузын эвсэл болсон боловч 680-аад оны үед түргийн харьяат болжээ. Гэвч токуз-огуз болон токуз-татарууд хамтран удаа дараа түргийн эсрэг цэрэглэн босож байсан тухай мэдээ занги сурвалжид гарч байна. Зарим нэг сурвалжийн мэдээ баримтаас үзвэл токуз-огузын дотор "харь" хэлтэн овог аймгууд цөөнгүй байсан ажээ. Тухайлбал, Махмуд Кашгарский (XI зуун) татаруудыг түрэг хэмээн үзэж байсан боловч "өөрийн хэлтэй" овог аймагт хамаатуулаад "тэд түргээр сайн ярьдаг боловч хоорондоо ярьдаг өөр хэлтэй" гэж онцлон дурдсан байдаг (Кумеков, 1972; Ибрагимов, Хроковский, 1958:95-97). Энэхүү хоорондоо ярьдаг өөр хэл гэдэг нь монгол хэл байх бололцоотой бөгөөд токуз-огуз болон түргийн бүрэлдэхүүнд энэ мэт монгол түрэг овог аймгууд зонхилж байсан нь тухайн үед олон хэв шинжийн оршуулгын зан үйл зэрэгцэн оршиход хүргэсэн бололтой.

МЭ I мянган жилийн II хагаст холбогдох монголчуудын гэж үздэг хэв шинжийн булш цөөн байгаа нь дурдсан нөхцөл байдалтай холбоотой боловч монгол овог аймгууд янз бүрийн нэрийн дор тэр цагийн түүхэн үйл явдалд оролцож байсан нь эргэлзээгүй бөгөөд зөвхөн мэн-у хэмээх угсаа гарвал, хэл соёлын хувьд төдийлөн тодорхой бус нэгэн аймгаар төлөөлүүлэн нийт монгол

хэлт овог аймгууд Х-ХI зууны үед Хар мөрөн (Амар) орчмоос баруун тийш нүүдэллэн Өвөр Байгал болон Монголын тал нутагт шилжин суусан гэх зарим судлаачдын таамаглал үндэслэл муутай болох нь харагдаж байна.

ТАЛАРХАЛ

Уг судалгааг хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн МУИС-ийн ARC (Азийн Судалгааны Төв) – д талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

- Арсланова Ф.Х., 1963. Средневековый могильник из Прииртышья. В кн.: Общественные науки, вып.III. История, философия, экономика (Сб. статей аспирантов и соискателей). Алма-Ата.
- Асеев И.В., 1975. О раннемонгольских погребениях ИКВА. т.III. Новосибирск.
- Асеев И.В., 1980. Прибайкалье в средние века (по археологическим данным). Новосибирск.
- Асеев И.В., Кириллов И.И., Ковычев Е.В., 1984. Кочевники Забайкалья в эпоху средневековья (по материалам погребений). Новосибирск.
- Батсайхан З., 1990. 1988-1989 онд Хэнтий, Өвөрхангай, Баянхонгор аймагт ажилласан ажлын тайлан. УБ.
- Батсайхан З., 2002. Хүннү. УБ.
- Волков В., 1963. 1959 онд Дундговь аймагт эртний хайгуул хийсэн тухай. Эртний судлал угсаатны зүйн бүтээл. Т.II. УБ.
- Гильом де Рубрук, 1988. Дорнод этгээдэд зорчсон минь. УБ.
- Ибрагимов С.К, Храковский В.С., Махмуд Кашгарский, 1958. О расселении племен на территории Казахстана в X веке. Вестник АН Каз. ССР. №11
- Именохоев Н.В., 1989. К вопросу о культуре ранних монголов. Этнокультурные процессы в юго-восточной Сибири в средние века. Новосибирск.
- Карпини П., 1988. Монголчуудын түүх. УБ
- Ковычев Е.В., 1981. Монгольские погребения из восточного Забайкалья. В кн. Новое в археологии Забайкалья. Новосибирск
- Кумеков Б.Е., 1972. Государство кимаков IX-XI вв. по арабским источникам. Алма-Ата
- Кюнер Н.В., 1961. Китайские известия о народах Южной Сибири Центральной Азии и дальнего Востока. М.
- Мэн-Да-Бэй-Лу, 1975. (Полное описание Монголо-татар) Факсимилие ксилографа Перевод с китайского введение, комментарий и приложения Н.Ц. Мункуева М., 1975
- Мэнэс Г., 1988. Отчет палеоэтнографического отряда за полевой сезон 1988 г. УБ.
- Наваан Д., 1975. Дорнод Монголын хүрлийн үе. УБ
- Наваан Д., 1983. 1983 оны хээрийн шинжилгээний тайлан. УБ.
- Путешествия в восточные страны Плано Карпини и Рубрука. 1975. Редакция, вступительная статья и примечания Н.П. Шастиной. М.
- Таскин В.С., 1989. Материалы по истории кочевых народов в Китае. Выпуск 1. Сюнну. (Перевод с китайского, предисловие и комментарии). М.
- Төрбат Ц., 2004. Хүннүгийн жирийн иргэдийн оршуулгын зан үйл (диссертаци). УБ.
- Федоров-Давыдов Г.Н., 1966. Кочевники Восточной Европы под властью золотоордынских ханов /археологические памятники/. М.
- Хамзкина Е.А., 1969. Телятниковский могильник. Этнографический сборник. Вып.5. Улан-Удэ.
- Gurvan gol. A report on the joint investigation under the Mongolian and Japanese "Gurvan gol" historic relic probe project (1991-1993)

ХАВСРАЛТ

1-р булш. Тахилгат толгойн баруун урд энгэрт оршино. Бага зэрэг зууван хэлбэрийн 2.5 м-ийн голч бүхий чулуун дараастай. 35 см-ийн гүнд чулуун дараас, 50 см-ийн гүнд булшны нүхний толбо илэрч толгойг нь чанх хойш хандуулан тэнэгэр байдлаар тавьсан эмэгтэй хүний оршуулга илрэв. Зүүн мөрний дээр тортонд ороосон дөрвөлжин хүрэл толь, түүний ойролцоо төмөр зэв, толгойн баруун дээд талд богийн шагай чөмөг тавьсан байв. Хүний яс ерөнхийдөө сайн хадгалагдсан бөгөөд гавлын яс бага зэрэг эвдрэлтэй. Хавирга, хөл болон гарын сарвуу, далны зарим хэсгээс бусад яс нь бүрэн.

3-р булш. Тахилгат уулын зүүн урд энгэрт оршино. Булшны хэмжээ голч нь 300 см, цагираг маягийн зууван дугуй хэлбэртэй. Чулуун дараасын зүүн урд хэсгээс 10 см гүнээс муу хадгалагдсан эрэгтэй хүний эрүүгүй гавлын яс гарлаа. 50 см гүнд 180x50 см хэмжээтэй булшны нүхний толбо илэрсэн бөгөөд 60 см гүнд 40x40 см дөрвөн тал чулуун хашлаганд нүүрээр нь доош харуулан тавьсан гавлын яс байлаа.

4-р булш. Тахилгат уулын оройн хэсэгт орших бөгөөд 400x250 см дугуйттар хэлбэрийн булш. 60 см гүнд уртрагийн дагуу булшны нүхний толбо илрэв. 95 см гүнд хөлийг жийлгэн гарыг нь биеийг дагуулан тавьж толгойг нь хойд зүгт чиглүүлэн тавьсан оршуулга илрэв. Яс анатомын байрлалаараа байлаа. Баруун гарын бугалганы хажууд үл мэдэгдэх төмөр эдлэл түүнчлэн амсар хэсэгтээ 10 см, доод хэсэгтээ 16 см өргөн, 60 см урт гурван төмөр зэв (сум) дүрсэн үйсэн саадаг байлаа. Мөн цээж, зүүн хөлийн өлмий орчмоос үл мэдэгдэх төмөр эдлэлийн хэсэг олдов. Булшны нүх 110 см гүн, 182 см урт, дээд хэсгээрээ 85 см, доод хэсгээрээ 60 см өргөн.

5-р булш. Тахилгат толгойн баруун хойт хэсэгт оршино. 2 м-ийн голч бүхий дугуй чулуун дараастай. 95 см-ийн гүнд анатомын бус байрлалтай хүний гавлын яс, эрүү болон мөчдийн ясны хэсгүүд, булшны нүхний баруун доод хэсэгт модны хэлтэрхий илрэв. Тус булш тоногдсон бөгөөд эд өлгийн зүйл гараагүй.

6-р булш. 5-р булшны зэргэлдээ орших тус булш 2 м-ийн голч бүхий дугуй чулуун дараастай. 95 см-ийн гүнд толгойг хойш чиглүүлэн тэнэгэр байдлаар тавьсан эмэгтэй хүний оршуулга илрэв. Баруун чихний тус газраас мөнгөөр хийсэн сүүжин ээмэг, зүүн мөрний дээрээс төмөр хутга гарсан. Хөл, гарын сарвууны зарим яснаас бусад яс бүрэн.

7-р булш. 6-р булшны хажууд орших тус булш 4 метрийн голчтой, бага зэрэг зууван хэлбэрийн чулуун дараастай. 60 см-ийн гүнд хойш харсан хүний гавлын яс гарсан. Булш тоногдсон бололтой.

8-р булш. 1-р булшнаас баруун хойт зүгт 10 метрийн зайд орших тус булш 40×2.40 м-ийн хэмжээтэй чулуун дараастай. Бага зэрэг баруун хойш чиглэсэн, толгойгүй, анатомын байрлалаар тавьсан эрэгтэй (?) хүний оршуулга илэрсэн. Баруун шууны орчмоос ногоон чулуу (оюу) хоёр ширхэг, зүүн мөрний орчмоос төмөр зэв (хавтгай) нэг ширхэг. Хос бугалга, эгэм, далны хэсэг, хавирганы хэсэг, аарцаг ясны хэсэг, дунд чөмөг, шилбэ байлаа. Булш тоногдсон бололтой.

9-р булш. 1-р булшнаас урагш. 2 м-ийн голчтой дугуй чулуун дараастай. 90 см-ийн гүнд авсны бололтой хавтгай мод, булшны нүхний дээд хэсгээс хүний шүднүүд баруун доод хэсгээс 50 см-ийн гүнд бөөрөнхий хүрэл товч гарсан.

10-р булш. Тахилгат толгойн баруун энгэрт оршино. 5 м-ийн голч бүхий бага зэрэг зууван чулуун дараастай. 1 м-ийн гүнд зүүн хойш толгойг чиглүүлэн тавьсан эмэгтэй (?) хүний оршуулга илэрсэн. Цээжин тус газраас ногоон ёнгийн 6 талт чулуун сувс гарсан. Гавлын яс бяцарсан, хавирга, сарвууны зарим яснаас бусад яс бүрэн.

11(а)-р булш. 10-р булшны ойролцоо оршино. 2.2 м-ийн голчтой, дугуй чулуун дараастай, 105 см-ийн гүнд толгойг бага зэрэг баруун хойш чиглүүлэн тавьсан эмэгтэй хүний оршуулга илэрсэн. Толгойн баруун талд хавтгай зэв, зүүн талд шаант чөмөг тус тус тавьсан байв. Сарвуу аарцаг ясны зарим хэсгээс бусад яс бүрэн.

11(б)-р булш. Тахилгат толгойн зүүн урд энгэрт орших 400×210 см хэмжээтэй зууван дугуй булш. 70 см гүнд $200 \times 85 \times 70$ см хэмжээтэй булшны нүхний толбо илрэв. 90 см гүнд толгойг нь хойд зүг чиглүүлэн тэнэгэр байдлаар тавьсан оршуулга илрэв. Яс анатомын байрлалаараа, зүүн гарын бугалганы хажууд үйсэн багтого малгай, төмөр хутга, зүүн мөрөн дээр зориулалт нь үл мэдэгдэх төмөр эдлэл зэрэг зүйлс гарлаа.

12-р булш. Тахилгат толгойн энгэрт орших 280×260 см хэмжээтэй дугуйтар булш. Булшны толгой хэсэгт 40 см орчим чулуун хөшөө босгожээ. Булшийг цэвэрлэх явцад төв хэсгээс хагарч хоёр хэсэг болсон жижиг ширмэн аяганы хагархай олдсон бөгөөд 70 см гүнд булшны нүхний толбо, 80 см гүнд хойд зүг толгойг нь чиглүүлэн тавьсан оршуулга илэрлээ. Нас барагчийг тэнэгэр байдалтай тавьсан байх ба яс анатомын байрлалаараа байлаа. Булшийг

малтах явцад 50 см гүнд төмөр зэв, арал болон бусад төмөр эдлэл гарлаа. Түүнчлэн чулуун дараасын доороос бог малын яс, болон гал түлсэн ор мөр илрэв.

Цувраа уул


3-р булш. 75 см-ийн гүнд бага зэрэг зүүн хойш толгойг чиглүүлэн тэнэгэр байдлаар тавьсан хүүхдийн оршуулга илэрсэн. Зүүн ташаанаас 5 ширхэг bog малын шагай 1 ширхэг төмөр эдлэл - хутга тавьсан байв.

4-р булш. Цувраа уулын зүүн хойд энгэрт орших 230x200 см дугуйтар хэлбэртэй булш. 60 см гүнд толгойг нь хойд зүг чиглүүлэн тавьсан хүүхдийн оршуулга байна. Яс анатомын байрлалаараа байгаа боловч баруун гарын шуу болон богтос байхгүй байлаа. Булшинд ямар нэг эд өлгө дагуулан тавиагүй байна.


Баян уул

6-р булш. 4 м-ийн голчтой, дугуй чулуун дараастай, 40 см-ийн гүнд 3x2 м-ийн талбайн баруун хойд хэсгээс ваарны хагархай гарсан. 1 м 70 см-ийн гүнд булшны нүхний толбо илэрсэн. Түүнээс доош 40 см-ийн гүнд хүүхдийн гавлын яс авсны дээд хэсгээс гарсан. Авсны урт 1 м 10 см, толгойн талын өргөн 48 см, хөл талын өргөн 38 см, өндөр нь 25 см, үл ялиг баруун хойш чиглүүлсэн хар модон банзан авс байлаа. Энэ хүүхдийн (5-7 нас) оршуулга тоногдсон бөгөөд яс нь хутгалдаж анатомийн бус байрлалтай болсон байв. Авсны хоёр хажуугийн хашлага нь дээд хашлаганаас дотуур углуурга гарган угсарчээ.

8-р булш. 6-р булшнаас баруун урагш 3 м-ийн зайд орших 6 м-ийн голчтой, дугуй чулуун дараастай 1 м 80 см-ийн гүнд булшны нүхний толбо илэрсэн. 4 м 80 см-т эх газрын хөрс илэрсэн. Баруун хойш чиглүүлсэн авсанд тэнэгэр байдлаар тавьсан ахимаг насны эрэгтэй хүний оршуулга байв. Зүүн мөрний хажууд TLV хүрэл цасан толь, зүүн шууны хажууд төмөр хутга, зүүн гарын сарвууны дээд хэсэгт бодын шагай, баруун мөрний орчим төмөр жад тус тус тавьсан байв. Модон авсны урт 1 м 74 см, дээд өргөн 73 см, доод өргөн 62 см, өндөр нь 40 см, хөндлөн банзаар шал, тагийг хийсэн, хоёр хажуу хашлага нь гадагш илүү гарсан ажээ.




Дорнод.. Хөлөнбуйр. Тахилгат уул. 6-р булш



Дорнод. Хөлөнбуйр. Өлзийтийн хүн чулуун хөшөө


Дорнод Монголын эрг дундад үеийн нүүдэлчид




Хэнтий, Мөрөн сум. Хүн чулуун хөшөө



Дорнод, Хөлөнбуйр. Тахилгат уул. 11-р булш



Дорнод, Хөлөнбуйр. Баян уул. 8-р булш. Жадны гилбэр



Дорнод, Хөлөнбуйр. Баян уул. 8-р булш. Авсны төмөр тоног

SUMMARY

Z.Batsaikhan

ANCIENT AND MIDDLE ANCIENT NOMADS OF EASTERN MONGOLIA

Results of the archaeological excavations conducted in 2003 in Bayan Uul and Tsuvraa Uul, Khulenbuir sum, Dornod aimag are presented in this paper.

Around 80 hunnu (Xiongnu) graves were discovered in Bayan Uul area, Khulenbuir sum, Dornod aimag. In northern slope of Tsuvraa Uul 10x10 m rectangular shape grave was excavated. By the round bronze mirror particle found in this grave and the shape and location of the grave, it is concluded that the grave belonged to Hunnu period. The most of the hunnu nobels graves are rectangular and locate in northern slope of mountain (Batsaikhan, 2002).

However, surface construction of other graves in Bayan Uul site is ellipsoid with a few stones on the surface. Three of these graves were excavated. Burials with wooden coffin with north orientation, weapons, knife and white bronze mirror of TLV type were revealed from these graves. Among the graves in Bayan Uul, Grave 6 was one of interest. Results of archaeological research of hunnu monuments in Transbaikalia and Northern Mongolia showed that there was no tradition of special child burial among Hunnu (Turbat, 2004). In this point the Grave 6 with child burial was exclusive among Hunnu graves in the region.

Most popular findings of male burial from Hunnu period are different kinds of heads and bone handles of arrow, but very rare iron swords and spears. In grave 8, Bayan Uul site we found a male burial in wooden coffin decorated with round iron knobs (iron), two spear tips of unusual shape (iron), particle of white bronze mirror in cork case. These findings show that besides of bow and arrow, different kinds of spears and swords were popular military weapons among Hunnu from this area.

In general, the Hunnu archaeological monuments in Bayan Uul site are very close to those from other areas in Mongolia and Transbaikalia and we regard them as the easternmost monuments of this period.